



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 107

Номгон

“Хос бичигтэн” аймгийн дэд
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хос бичигтэн” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Дэд хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

0117257



**“ХОС БИЧИГТЭН” АЙМГИЙН
ДЭД ХӨТӨЛБӨР**

**НЭГ. ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ
ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА**

Үндэсний бичиг бол хүн төрөлхтний бүтээсэн оюуны соёлын салшгүй нэгэн хэсэг бөгөөд энэхүү бичгийг монголчууд XIII зуунаас эхлэн хэл аялгуундаа тохируулан хэрэглэж, улам төгөлдөржүүлэн, олон зүйл мэдлэг ухааны туурвил бүтээлийг бий болгожээ. Монголын ард түмний соёлын өв болсон монгол бичгийг хадгалан хамгаалж, эзэмшин хэрэглэж, төгс төгөлдөр болгох нь хүн төрөлхтний өмнө монголчуудын хүлээсэн үүрэг мөн.

Монгол хэлний тухай хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутаг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох аймгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

Хөтөлбөрийг Монгол хэлний тухай хуулийн үндсэн зарчмуудад тулгуурлана.

2.1. Монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн.

2.2. Монгол хэл, бичиг үсгийг эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах нь төрийн үүрэг мөн.

2.3. Монгол улсын иргэн бүр монгол хэл, бичиг үсгээ сурах, монгол хэлээр мэдээлэл авах, өвлөх, өвлүүлэх, хамгаалах, хөгжүүлэх боломж, нөхцөлөөр хангагдах эрхтэй.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Монголчуудын оюуны соёлын салшгүй бүрэлдэхүүн, давтагдашгүй өв болсон монгол бичгийг ард иргэдэд эзэмшүүлэх, хойч үедээ өвлүүлэх орчин нөхцөлийг бий болгож, улмаар бүх нийтийн хэрэглээний бичиг болгоход дэмжлэг үзүүлэхэд энэхүү хөтөлбөрийн гол зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна.

3.1. Үндэсний бичгийн сургалтын болон хэрэглээний орчныг сайжруулж, хэрэглээг нэмэгдүүлэх

3.2. Төрийн албан хаагчийн үндэсний бичиг сурах болон хэрэглээний чадварыг сайжруулах

3.3. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, иргэдэд үндэсний бичгийг албан ба албан бус сургалтаар зааж сургах

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ

АРГА ХЭМЖЭЭ

4.1. Хөтөлбөрийн нэгдүгээр зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.1.1. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын хаягийг үндэсний бичиг, кирил, англиар хослуулан бичиж, хэвших ажлыг зохион байгуулах

4.1.2. Ерөнхий боловсролын сургуулийн үндэсний бичгийн сургалтын танхимын орчныг сайжруулан, сургалтад хэрэглэж байгаа компьютерт програм суулгаж, түүнийг ашиглаж хэрэглээ болгох

4.1.3. Насан туршийн боловсролын нэгжийг түшиглэн үндэсний бичиг сурах орчин бүрдүүлэх

4.1.4. Цахим орчинд үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх

4.1.5. Кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрэм, толь бичгийг хэрэглэж хэвшүүлэх

4.1.6. Төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн санаачилгаар зохион байгуулах үндэсний бичиг сургах, сурталчлахад чиглэсэн санал санаачилгыг дэмжих

4.2. Хөтөлбөрийн хоёрдугаар зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2.1. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварын түвшинг тогтоож, тэдэнд зориулсан сургалтыг үе шаттай зохион байгуулах

4.2.2. Төрийн албан хаагчдын үндэсний бичиг сурах болон хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх олон төрлийн ажил, арга хэмжээ зохион байгуулах

4.2.3. Төрийн албан хаагчдад үндэсний бичгийг хэрэглэх орчин бүрдүүлэхэд анхаарах

4.2.4. Төрийн албан хаагчдад цахим орчинд үндэсний бичгийг хэрэглэх хэрэглээг нэмэгдүүлэх

4.2.5. Монгол хэл, бичгийн багш нарыг чадваржуулах олон төрлийн ажил, арга хэмжээ зохион байгуулах

4.3. Хөтөлбөрийн гуравдугаар зорилтын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.3.1. Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, бичгийн сургалтын чанарыг сайжруулах

4.3.2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, иргэдийн монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт.

5.1. Хос бичигтэн аймаг дэд хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулна.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сум, багийн хэмжээнд бүх шатны Засаг дарга нар зохион байгуулна.

5.4. Хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг аймгийн ИТХ-д жил бүр тайлагнана.

ЗУРГАА . ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

6.1. "Хос бичигтэн" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг зорилгодоо нийцүүлэн хийж, шалгуур үзүүлэлтийн дагуу зардлыг нарийвчлан тооцож жил бүрийн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

6.2. Иргэд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс санхүүгийн дэмжлэг авч болно.

_____ оОо _____